



ЦЭЭЛ СУМЫН НЭГДСЭН ТАЙЛАН ОРОН НУТГИЙН ТУСГАЙ САНГУУД

2013 оны Санхүүгийн тайлан

Аудитыг дуусгавар болгосон тухай тайлан

Төв аймгийн Аудитын газар нь Төрийн Аудитын тухай хуульд заасан Аймгийн аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд улсын болон орон нутгийн төсвөөс санхүүждэг төсөвт байгууллагын санхүүгийн тайланд нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим холбогдох хууль, журам зааварт нийцүүлэн аудит хийж байна.

Лавлах зүйлс байвал доорх хаягаар холбоо барина уу:

Аймгийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор
Л.Жаргалсайхан

Утас: 70272582

И-мэйл

Jargalsaikhan_tuv@yahoo.com

Аудитор

Ц.Базарсад

Утас: 7027-2287

И-мэйл

Bazaraatsend@yahoo.com

ТӨАГ-ын хаягийг оруулах

Төв аймаг Зуунмод сум 1-р баг

Төрийн байгууллагуудын

ордон

АГУУЛГА

ХУУДАС

• Танилцуулга	4
• Санхүүгийн дотоод хяналт	4
• Гол шийдлүүд	7
• Залруулаагүй алдаа	7
• Тайлбар мэдүүлгийн захидал.....	7
• Аудитын санал дүгнэлт	8

Цээл сумын 2013 оны Санхүүгийн нэгдсэн тайланд ААГ аудит хийж дууссан тухай мэдэгдэл

1. Бид Цээл сумын нэгдсэн 2013 оны Санхүүгийн тайланд аудитаа хийж бараг дуусаж байгаа ба Цээл сумын Төсвийн Ерөнхийлөн захирагчид энэхүү аудит хийж дуусгах тухай мэдэгдлийг өргөн барьж улмаар энэхүү санхүүгийн тайланг дахин шалган нягталж бидэнд туслахыг хүсч байна. Удирдлагын захидал хэмээх тусдаа хэсэгт санхүүгийн хяналтыг сайжруулах талаарх бидний өгсөн зөвлөмжүүд орсон бөгөөд Цээл сумын Удирдлага тухайн зөвлөмж бүрд хариу явуулна уу.

Удирлагын зөвлөлийн анхаарлыг дараах зүйлд чиглүүлж байна:

- Гол санхүүгийн хяналтууд хамрагдсаныг **тодруулбал:**

НББ-ийн үе шат бүрд дээд шатны түвшний удирдлага хүрдэг эсэх, нийтлэг чанартай зардал, төсвийн санхүүжилт, өөрийн орлого, цалингийн зардал, өглөг, авлага, балансын үзүүлэлтүүд, үндсэн хөрөнгө, бараа материал, бусад асуудлуудыг хамруулсан бөгөөд байж болзошгүй эрсдлийг тооцож холбогдох батламж мэдэгдлүүд хэрхэн хангагдаж байгааг нотлох үүднээс холбогдох стандарт, журам зааврын дагуу шаардлагатай горимыг хэрэгжүүлсэн.

- Гол илрүүлсэн зүйлс аудитын үр дүнгээс гарсныг **тодруулбал:**

- ЕМ, Санхүүгийн албаны даргаас ААГ тайлбар мэдүүлэг хүлээж байгаа
 - -Илэрсэн алдааг хэрхэн залруулсан талаар тайлбар ирүүлнэ үү
- Аудитыг дуусгаж аудитын явцад олж авсан ажлын баримтанд үндэслэн зөрчилгүй дүгнэлт гаргахааар Ерөнхий аудиторт санал оруулсан байгаа
- Ерөнхий Аудитор 2014.03.03-ны өдөр санал дүгнэлтэнд гарын үсэг зурна.

Эцэст нь аудитын явцад Төрийн сангийн мэргэжилтэн Ж.Гандулам, нягтлан бодогч Ц.Батбаяр, М.Дэнсмаа, Д.Нарангэрэл, Д.Төмөртоогоо болон бусад бидэнтэй хамтран ажилласан ажиллагсдын байнгын

дэмжлэг туслалцаа бидний ажилд дэмжлэг
болж байсанд гүнээ талархаж байна.

Төв аймгийн Аудитын Газар

2014.03.10

Танилцуулга

1. Бид Цээл сумын нэгдсэн тайлангийн 2013 оны 12 дугаар сарын 31-р тасалбар болсон санхүүгийн тайланд аудитаа хийж бараг дуусаж байгаа ба Засаг даргад энэхүү аудит хийж дуусгах тухай мэдэгдлийг өргөн барьж улмаар энэхүү санхүүгийн тайланг дахин шалган нягталж бидэнд туслахыг хүсч байна. Удирдлагын захидал хэмээх тусдаа хэсэгт санхүүгийн хяналтыг сайжруулах талаарх бидний өгсөн зөвлөмжүүд орсон бөгөөд Цээл сумын Засаг дарга тухайн зөвлөмж бүрд хариу явуулна уу.
2. Бидний 2013 онд тайланд хийсэн аудит нь 2 гол элементтэй:
 - Санхүүгийн хяналтын системийг дахин шалгах;
 - Жилийн санхүүгийн тайланд аудит хийх.Аудитаас үүдэн гарсан асуудлууд дараах хэсэгт хураангуйлагдсан.

Жилийн санхүүгийн тайланд аудит хийх.

3. ААГ санхүүгийн хяналтыг дахин шалгаж үзээд санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг баталгаажуулах шаардлагатайг авч үзсэн. Бидний дахин шалгалт нь Цээл сумын Засаг даргын н хяналтыг ААГ-ын санхүүгийн эрсдэл ба хяналтын мэдээтэй харьцуулан шинжлэн үзсэн. Үүний үр дүнд цаг ямагт үр өгөөжтэй материаллаг алдаанаас сэргийлж чадах гол санхүүгийн хяналтыг онцгойлон үзсэн юм. Бид Цээл сумын Засаг даргад тухайн жилийн эдгээр хяналтын асуудлын тухай тайлагнасан.
4. Дараахь түвшний хяналтын асуудал бидний дахин шалгалтын үр дүнгээс гарсан бөгөөд үүнд Цээл сумын Засаг дарга удирдлагын анхаарлыг хандуулж байна.

1. Санхүүгийн дотоод хяналтын талаар

Цээл сумын төсөвт байгууллагууд нь үйл ажиллагаанд дотоод хяналт, шалгалтыг зохион байгуулах журам болон хяналт шалгалтыг зохион байгуулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг томилсон боловч дотоод хяналт шалгалтыг сургуулиас бусад байгууллага огт хийгээгүй байна. Сургуулийн дотоод хяналтын комисс эрсдлийн аудитаар өгөгдсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Сумын хэмжээгээр төрийн сангийн зүгээс байгууллагуудын санхүүд хяналт шалгалт огт хийгдээгүй, төрийн сангийн гүйлгээнүүдийн анхан шатны баримтын бүрдэлгүйгээр гүйлгээ хийсэн, зардлын бүлэг дотороо гүйлгэн зарцуулсан гүйлгээнүүдийг хэтрэлт хэмнэлтээр нь тооцохгүй төсөвтэй зардал тус бүрээс нь гаргасан, бүлэг хооронд гүйлгэн зарцуулсан гүйлгээнүүдэд ЗЭБ-1 маягтаар зөвшөөрөл авалгүйгээр гүйлгээнүүдийг хийсэн байна.

2012 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар 2 актаар 2726,4 мянган төгрөгийн төлбөрийн акт тавигдсанаас 406.0 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна. Үлдэгдлийг сум хөгжүүлэх сангийн зээлдэгч Шүхэрдулам 206.0 мянган төгрөг, 200.0 мянган төгрөгийг төлүүлэхээр тохиролцсон тул 2014 оны 3-р сарын 30-ны дотор бүрэн барагдуулна гэсэн аман яриатай байна..

Мөн 3 албан шаардлагаар 49650.6 мянган төгрөгийн албан шаардлага бичигдсэнээс хариуг 2013.07.04-ний 04/176 тоотоор хариу ирүүлсэн байна. Хугацаа хэтэрсэн зээлтэй иргэдэд мэдэгдэл өгч , өгсөн хугацаанд барагдуулахгүй бол шүүхээр

шийдвэрлүүлэхээр сум хөгжүүлэх сангийн ажлын хэсэг шийдвэрлэсэн гэсэн хариуг ирүүлсэнийг газар дээр нь эрсдлийн аудитаар үзэхэд барагдуулалт хангалтгүй байсан.

2.Орлого, санхүүжилтийн талаар

Цээл сумын ИТХурлын 2012 оны 12-р сарын 26-ны өдрийн 06 тоот тогтоолоор нийтийн ерөнхий үйлчилгээний төсвийг 271939.9 мянган төгрөгөөр батласан байна. Үүнд сумын ЗДТГазар 192174.3 мянган төгрөг, Баг 46074.5 мянган төгрөг, ИТХурал 33691,0 мянган төгрөгийн төсөвт зардал батлагдсан байна. Үүнийг орон нутгийн татварын орлогоор 25375.2 мянган төгрөг, аймгийн санхүүгийн дэмжлэгээр 246564.7 мянган төгрөгийн эх үүсвэр бүрдүүлэхээр батлагдсан байна.

Аудитын явцад тулган баталгаажуулалтыг хийхэд:

ЗДТГ-ын өөрийн орлого 596.7 мянган төгрөгийн интернетийн орлого төвлөрүүлж, 391.2 мянган төгрөг зарцуулсан.Нэмэлт дансаар авч орлогыг тусгаагүй байсныг залруулсан.

1.1 Татварын орлогын мэдээ нь төрийн сангийн хуулганаас 90.0 мянган төгрөгөөр дутуу зөрүүтэй байна.

Цээл сумын ИТХурлын 2012 оны 12-р сарын 26-ны өдрийн 06 тоот тогтоолоор 2013 оны орон нутгийн орлогыг 25375.2 мянган төгрөгөөр баталсан байна.

2013 оны жилийн эцсийн байдлаар 3 шатны орлого 128868.9 мянган төгрөгийн төлөвлөгөө батлагдаж гүйцэтгэлээр 102465.6 мянган төгрөгийн татварын орлого орж батлагдсан төлөвлөгөөг 26403.3 мянган төгрөг буюу 21.0 хувиар тасарсан байна. Үүнийг 3-н шатанд төвлөрүүлэх байдлаар нь задлавал:

- ✓ Орон нутгийн орлого 7447.2 мянган төгрөг төлөвлөгдснөөс гүйцэтгэлээр 16408.0 мянган төгрөгийн татварын орлого орж орлогын төлөвлөгөөг 8760.8 мянган төгрөг буюу 214.6 хувиар давуулан биелүүлсэн
- ✓ Аймагт төвлөрүүлэх орлого 80636.7 мянган төгрөг төлөвлөгдснөөс гүйцэтгэлээр 78067.9 мянган төгрөгийн татварын орлого оруулснаас орлогын төлөвлөгөөг 2568.8 мянган төгрөг буюу 3.2 хувиар тасарсан
- ✓ Улсад төвлөрүүлэх орлого 35607.0 мянган төгрөг төлөвлөгдснөөс гүйцэтгэлээр 6909.3 мянган төгрөгийн татварын орлого оруулснаас орлогын төлөвлөгөөг 28697.7 мянган төгрөг буюу 81.0 хувиар тасарсан байна.

Татварын орлогын биелэлтийг нэр төрлөөр нь задлавал :

- Ой татвар 3740.6 мянган төгрөг буюу 4.4 дахин
- Хүү торгууль 913.0 мянган төгрөг буюу 2.2 дахин
- Газрын төлбөр 12288.0 мянган төгрөг буюу 2.1 дахин биелүүлсэн бол
- Усны төлбөр 7000.0 мянган төгрөг буюу 100.0 хувиар
- НӨАТатвар 29478.2 мянган төгрөг буюу 99.7 хувиар
- ААНОАТатвар 2893.6 мянган төгрөг буюу 31.0 хувиар
- ХХОАТатвар 8487.4 мянган төгрөг буюу 15.0 хувиартус тус тасарсан байна.

Тайлант оны дутуу төлөлтийг татварын улсын байцаагч байгаагүй учир гаргах боломжгүй байлаа.

Татварын орлогын нэр төрлөөрх гаргасан мэдээг төрийн сангийн хуулгын дүнтэй тулган шалгахад орон нутгийн орлого татварын мэдээгээр 16408.0 мянган төгрөг, төрийн сангийн хуулгаар 20481.6 мянган төгрөг зөрүү 4073.6 мянган төгрөгийн зөрүүтэй байна. Орон нутгийн орлогын дансанд орон нутгийн ерөнхий орлогын дансны үлдэгдэл 3447.2 мянган төгрөгийг татан төвлөрүүлснээс орлого зөрж байна үүнийг хасч тооцвол 626.4 мянган төгрөгөөр зөрүүтэй байна. Үүнийг зарлагаас нь тулгаж шалгавал Баян сумын гүйлгээг 173.5 мянган төгрөг, Эрдэнэсант 172.9 мянган төгрөг, Татварын данс андуурагдсан 190.0 мянган төгрөгийн андуурагдсан гүйлгээг буцаан шилжүүлсэн 536.4 мянган төгрөгийн гүйлгээг хасч тооцвол 90.0 мянган төгрөгөөр орон нутгийн орлогын мэдээ дутуу мэдээлэгдсэн байна. Цаашид ХААН банкны данс андуурагдсан гүйлгээг хийлгэхгүй байх талаар анхааруулж хариуцлагатай ажиллах талаар гэрээ байгуулж ажиллах шаардлагатай байна.

1.1. Төрийн сангийн нягтлан бодох бүртгэлийн программ / MNSan/-аар орон нутгийн татварын орлогыг нэр төрлөөр тайлагнаж байна.

Сумын төрийн санд орон нутгийн орлогын 142400995 тоот дансанд татварын орлого орж тайлагнагдсан байна. Сумын төрийн сангийн нягтлан бодох бүртгэлийн MNSan программаас татварын орлогын нэр төрлөөр 1-р улирлын байдлаар боловсруулагдсан тайлан гаргасан байна. Татварын улсын байцаагч банкны хуулга авч татварын нэр төрлөөр орлогыг боловсруулж мэдээ гаргаж байна.

Цээл сумын орон нутгийн өмчийн хөрөнгийг Хадгаламж банканд түрээслэсэн, ХААН банк, Хадгаламж банкны халаалтын зардал зэргээс төсөвт газрын өөрийн орлогыг бүрдүүлж орон нутгийн орлогын дансанд 1343.6 мянган төгрөгийг төвлөрүүлж батлагдсан төлөвлөгөөг 141.0 хувиар давуулан биелүүлсэн байна.

3.Мөнгөн хөрөнгө

2013 онд нийтийн ерөнхий үйлчилгээнд 271939.9 мянган төгрөгийн төсөвт зардал батлагдсанаас гүйцэтгэлээр 269876.9 мянган төгрөгийн эх үүсвэрийг санхүүжүүлж орон нутгаас авах 2063.0 мянган төгрөгийн эх үүсвэрийг дутуу авч аймгийн санхүүгийн дэмжлэг 246564.7 мянган төгрөгийг бүрэн авсан байна.

ЗДТГазар 167499.1 мянган төгрөгийн урсгал санхүүжилт, 22612.2 мянган төгрөг орон нутгийн орлогоос, үндсэн бус үйл ажиллагааны орлого 596.7 мянган төгрөг, нэмэлт санхүүжилтээр 47877.6 мянган төгрөг нийт орлого 238585.7 мянган төгрөгийн орлого, 284442.6 мянган төгрөгийн зарлага тайлагнасан.

ИТХ 33491.0 мянган төгрөгийн урсгал санхүүжилт, 200.0 мянган төгрөг орон нутгийн санхүүжилтээс, 621.0 мянган төгрөг өмнөх оны үлдэгдэл нийт 31944.6 мянган төгрөгийн орлого, 38582.2 мянган төгрөгийн зарлага тайлагнасан.

БАГ 45574.5 мянган төгрөгийн урсгал санхүүжилт, 500,0 мянган төгрөг орон нутгийн санхүүжилтээс, үндсэн бус үйл ажиллагааны орлого 3774.9 мянган төгрөг, 52103.3 мянган төгрөгийн зарлага тайлангасан байна.

Тайлант онд

ЗДТГ 47674,5 мянган төгрөг нэмэлт төсвийн дансны орлогоор орж 47339,7 мянган төгрөгийг зарцуулж 334,8 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна. Зарцуулалтын

тайлангаар цалингийн зардалд 23546,7 мянган төгрөг, Хоолны зардалд 1272,0 мянган төгрөг, Урсгал засварт 765,0 мянган төгрөг, Эд хогшил худалдан авах зардалд 1000,0 мянган төгрөг, Нэг удаагийн тэтгэмж урамшуулалд 5770,4 мянган төгрөгийн зарцуулсан байна.

БАГ Нэмэлт төсвийн дансны орлогоор 896.9 мянган төгрөг орж зарцуулагдаагүй 896.9 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.ИТХ нэмэлт төсвийн дансаар орлого байхгүй.

ЗДТГазар: цэвэрлэх гүйлгээгээр 2991.8 мянган төгрөг хийсэнээс лист 1630.5 мянган төгрөг, ХАОАТ-ын буцаалт 5 хүнд 1361.3 мянган төгрөгийн гүйлгээнүүд хийгдсэн.

Санхүүгийн үйл ажиллагаанд Acolloous программыг бүрэн өдөр тутам ашигладаг. Цалинг цалингийн тусгай программ ашигладаггүй. Нярав программ ашигладаггүй гараар хийснийг нягтлан бодогч программд шивж оруулдаг.

4.Бараа үйлчилгээний зардал

5.Цалингийн талаар

Цалингийн зардлыг пивотоор шалгахад :

ИТХ нь Мөнгөн гүйлгээний тайлангаар 26947.3 мянган төгрөг , Үр дүнгийн тайлангаар 29160.7 мянган төгрөгийн гүйцэтгэлтэй гарч 2213.5 мянган төгрөгийн өглөгийг, өглөгийн тайлантай тулгахад өглөгийн тайланд 2033,2 мянган төгрөгөөр тусгагдсан нь 1477.6 мянган төгрөг цалингаас суутгасан шимтгэл, ХАОАТ 555.6 мянган төгрөгийн өглөг үүсэж, НДШ-ийн хэмнэлт 180.2 мянган төгрөгийн хэмнэлт цалин гүйлгэн зарцуулсан.

6.Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн дансанд Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр бэлтгэсэн хог түр хадгалах сав 4000.0 мянган төгрөг, модны хөрөө рам 10000.0 мянган төгрөг, хог цэвэрлэгээ үйлчилгээнд хогны машин 4150.0 мянган төгрөг, 12 айлын орон сууцны сангийн засвар 47026.3 мянган төгрөг, гэрэлтүүлэг 15990.0 мянган төгрөг нийт 81166.3 мянган төгрөг орлого авсан.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 3 худаг нийт 40711.7 мянган төгрөгийн хөрөнгө, Аймгийн төсвийн хөрөнгө оруулалтаар цагдаагийн газрын кобон 66410.5 мянган төгрөг, сумын цэцэрлэгт хүрээлэн 13800.0 мянган төгрөг, интернет мэдээллийн төвд зөөврийн 918.3 мянган төгрөг нийт 81128.8 мянган төгрөг бүгд 203006.8 мянган төгрөгийг орлого авсан байна.

Үнэ төлбөргүй авсан 203006.8 мянган төгрөгийн хөрөнгийн санхүүгийн тайланд тусгахдаа засгийн газрын санг нэмэгдүүлж авсаныг залруулж хөрөнгийн орлого дансаар бүртгэсэн.

ЗДТГазар үндсэн хөрөнгийн данснаас 2013.12.25-ны 55 тоот ИТХ-ын тогтоолоор 11403.8 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө, 872.7 мянган төгрөгийн хөрөнгийн бараа материал актлах шийдвэрийн дагуу хасалт хийсэн байна.

Үүнээс: авто тээврийн хэрэгсэл 2091.6 мянган төгрөгийн мотоцикл-2ш, тоног төхөөрөмжөөс 7432.4 мянган төгрөг, тавилга эд хогшлоос 1879.7 мянган төгрөг актлагдсанаас тоног төхөөрөмжөөс 6 нэр төрлийн 798.9 мянган төгрөгийн элэгдэлээ

нөхөөгүй, тавилга эд хогшлоос 7 нэр төрлийн 547.9 мянган төгрөгийн элэгдлээ нөхөөгүй хөрөнгийг гарз үүсгэн бүртгэсэн байна.

Өмнөх оны хөрөнгө оруулалтаар хийгдсэн худаг 12.7 сая төгрөг, Цэцэрлэгт хүрээлэн 13.8 сая төгрөг, Цагдаагийн кабон 66.4 сая төгрөгийн хөрөнгүүдийн 3-р улирлын байдлаар орлого авч санхүүгийн тайланд тусгасан байна.

7.Бараа материал

Бараа материалын анхан шатны баримтыг урьдчилан дугаарлаж цаг хугацаанд нь бүрэн хөтөлснийг шалгахад шаардах хуудас болон зарлагын баримтанд нягтлан бодогчийн гарын үсэггүй, Мөн шаардах хуудасны материал зарлагадах тоо хэмжээг дарга нягтлан бодогчоор цохуулалгүй эд хариуцагч шууд бичилт хийж зарлагдаж байгаа зөрчил гарсаар байна.

Анхан шатны баримтын бүрдэлийг шалгахад цалингийн тооцооны хүснэгтэнд ажилчдын гарын үсгийг тухайн сард багтаан гарын үсэг зуруулж бүрдэл болсон баримтаар гүйлгээ хийгдэх нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн заалт хэрэгжихгүй байна.

Эд хариуцагч нярав нь шатахууны тайланг гаргахдаа зохих маягтаар хийж тайлагнасан байна. Гэвч 1. 6. 8. 9-р саруудын шатахуун тайлангийн зарцуулалтын тайланг гараагүй аудитын явцад нягтлан бодогч үзүүлээгүй болно. Үүнээс дүгнэхэд шатахууны тайлан гараагүй байхад нягтлан бодогч шилжүүлсэн мөнгөний хэмжээгээр шууд зардалд хааж байна гэсэн дүгнэлтэнд хүрч байна. Гэхдээ шатахуун олгох зөвшөөрөл нь замын хуудастай тохирч байх ёстой байтал замын хуудасгүй байна. Иймд шатахуун авах зөвшөөрөлийн бичгийг замын хуудастай тулган шалгаж тайлагнаж хэвших ба замын хуудасгүй шатахууныг авсан хэрэглэгчээр төлүүлэх арга хэмжээ авч ажиллах шаардлагатай байна. Нягтлан бодогч нь жолоочийн тооцоог бодоогүй байна.

Хөрөнгийн тооллого хийсэн байна . Тооцоо бодсон акт хийгдээгүй байна. Тооллогын комиссын илтгэх хуудасыг бичүүлж тооцоог бодож хэвшээгүй байна. Зөвхөн тооллого хийгээд орхисон байна.

Эд хариуцагчийн карт хөтлөсөн боловч эд хариуцагчаар болон тооллогын комиссын гарын үсэггүй баталгаажуулаагүй зөвхөн эд хариуцагч өөрөө бичсэн байна. Үүнээс хөрөнгийн маргаан гарахад хүлээж аваагүй гэсэн асуудал гарах эрсдэлтэй байна. Иймд эд хариуцагчийн картыг бүрэн гарын үсэг зуруулж албажуулан баталгаажуулах хэрэгтэй байна.

8.Авлага ,өглөгийн талаар

ИТХ нь: Цалингаас суутгасан ашиг 1899.7 мянган төгрөг,НДШ 5314.7 мянган төгрөг, байгууллагаас төлөх НДШ 2783.8 мянган төгрөг

Баг нь: Цалингаас суутгасан ашиг 2763.3 мянган төгрөг, суутгасан НДШ 7229.0 мянган төгрөг, байгууллагаас төлөх НДШ 3594.2 мянган төгрөг

ЗДТГ нь: цалингаас суутгасан ашиг 10854.1 мянган төгрөг, суутгасан НДШ 12827.0 мянган төгрөг байгууллага төлөх НДШ 14733.4 мянган төгрөг

Нийт цалингийн ашиг 14678.7 мянган төгрөг, суутгасан НДШ 19218.6, байгууллага төлөх НДШ 21140.4 мянган төгрөгийн суутгалуудыг тулгахад эхийн чөлөөтэй,

гэрээтийн цалингийн 279.8 мянган төгрөгийн өглөгийг тайланд тусгаагүй байсныг залруулсан.

Цахилгаан ЗДТГ нь цахилгааны бичилтээр 2816.0 мянган төгрөг нэхэмжлэсэнийг бүрэн барагдуулж тооцоо нийлсэн актаар үлдэгдэлгүй гэдгийг баталгаажуулсан

Нийгмийн даатгалын шимтгэлийн тооцоо нь байгуулсан НДШ 40691.9 мянган төгрөг байгуулсанаас гүйцэтгэлээр төлсөн 38874.3 мянган төгрөг төлж авлагын үлдэгдэл 53.0 мянган төгрөгийн хасаж 1764.5 мянган төгрөгийн үлдэгдэлтэйгээр тооцоо нийлж баталгаажуулсан байна.

Татварын хэлтэстэй хийсэн татварын тайлангаар 172967.4 мянган төгрөгийн татвар ноогдох орлогын дүнгээс хуулийн хөнгөлөлтөөр 2618.0 мянган төгрөгийг хасаж тооцоход ЗДТГазар тооцсон татвар 10854.1 мянган төгрөг төлөхөөс 11692.5 мянган төгрөг татвар төлж 838.3 мянган төгрөг авлага үүсгэсэн, ИТХ нь тооцсон татвар 1899.7 мянган төгрөг төлөхөөс 1344.1 мянган төгрөг төлж 555.6 мянган төгрөгийн өглөг үүссэнийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй байна.

Бичиг хэргийн зардлын тооцоогоор өглөг авлага үүсгэхийг хувь хүмүүсээс авах авлага гэж зөрүүтэй бүртгэсэн. Баг нь бичиг хэргийн зардлын орлогыг өглөг, авлагын тооцооны дансаар дамжуулаагүй бусад өглөгөөр дамжуулж Бараа материалын тодруулгын тайлангаар 442.3 мянган төгрөгийн материалын орлогыг /бичиг хэргээс 162.0 мянган төгрөг, шуудан холбооноос 150.0 мянган төгрөг, ном хэвлэлээс 131.0 мянган төгрөг тус тус шилжүүлж/, 442.3 мянган төгрөгийг тайлант онд авсан хэмжээгээр зарцуулсан байна. Гэтэл үр дүнгийн тайлангаар 261.3 мянган төгрөг зарцуулж 181.0 мянган төгрөгийг өөр өөр зардлаас орлого авсанаараа шуудан холбооны зардал 87.5 мянган төгрөг, ном хэвлэлийн 93.5 мянган төгрөг гэж бичиг хэргийн материалын данснаас зарлагадсан байна.

Шуудан холбооны зардлаас 150.0 мянган төгрөг шилжүүлж бичиг хэргийн материал авсан, мөн зарлагдахдаа 87.5 мянган төгрөгийг нь шуудан холбооны зардлаар үр дүнгийн тайланд тусгасан.

Урсгал засварын зардлаас 400.0 мянган төгрөг шилжүүлж 67.0 мянган төгрөгийг нь оношлогоонд, 83.0 мянган төгрөгөөр аж ахуй материал авч бараа материалын тодруулгын тайланд тусгаад зарлагдахдаа урсгал засварын зардал гэж үр дүнгийн тайланд тусгасан байна.

9.Тусгай зориулалттай сангуудын талаар

Төсвийн ерөнхийлөн захирагчийн дэргэд “Засгийн газрын тусгай сангуудын тухай хууль”-ийн 5.4-т заагдсан дараах тусгай сангууд байна.

Сум хөгжүүлэх сан, Мал хамгаалах сан, Байгаль хамгаалах сан, Орон нутгийн хөгжлийн сан , Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх сан, Халамжийн сан гэсэн 6 сангууд байна.

Сумын Засаг даргын захирамжаар сум хөгжүүлэх сангийн зөвлөлийн бүрэлдэхүүнийг томилсон байна. Сангийн хөрөнгийг захиран зарцуулах эрхийг “Сум хөгжүүлэх сангийн зөвлөл”-ийн шийдвэрийг үндэслэн сумын төсвийн ерөнхийлөн захирагч бөгөөд сумын Засаг дарга хэрэгжүүлж байна.

Сангуудын санхүүгийн тайланг сан тус бүрээр нь батлагдсан санхүүгийн тайлан, тодруулгын маягтуудын дагуу гаргасан байна.

МАЛ ХАМГААЛАХ САН

Мал хамгаалах сангийн оны эхний үлдэгдэл 3475.0 мянган төгрөгийн үлдэгдлээс 3000.0 мянган төгрөгийн өвс улсын нөөцөд 11 сард иргэн Чүлтэмсүрэнгээс худалдаж авсанаа цаг агаар хүндрэлгүй байгаа учраас 2013.12.25-нд хүнд нь буцааж 3000.0 мянган төгрөгийг дансанд төвлөрүүлсэн байна. Мөн Этүгэн дээд сургуулийн малын хөлийн татвар гэж 215.0 мянган төгрөгийн орлого орж эцсийн үлдэгдэл 3555.0 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

2013.11.19-нд малчид, оторчидоор явах гэж 135.0 мянган төгрөгийн бензин шилжүүлэн 75*1800 авч шаардахаар зарлага гаргаж хаана байдаг оторчидыг эргэсэн гэдгийг нотлох баримтгүйгээр шууд зардалд бичсэн байна.

ГЭМТ ХЭРГЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ САН

Оны эхний үлдэгдэл 103.8 мянган төгрөг, томилолтын зардал 70.0 мянган төгрөг зардал олгож 33.8 мянган төгрөгийн үлдэгдэлтэй гарсан байна.

БАЙГАЛЬ ХАМГААЛАХ САН

Төрийн сангийн 142455404 тоот дансаар оны эхний үлдэгдэл 134.6 мянган төгрөг, орлого нь 12000.0 мянган төгрөгийн санхүүжилт, хог хаягдлын хураамж 87.5 мянган төгрөг, био техник арга хэмжээний зардал 2000.0 мянган төгрөг, морин эргүүлийн 300.0 мянган төгрөг нийт 14387.5 мянган төгрөгийн орлого орж гүйцэтгэлээр хог цэвэрлэх ажилчдын цалинд 450.0 мянган төгрөг шатахуунд 1050.0 мянган төгрөг нийт 1500.0 мянган төгрөгийг хогийн цэгийн тохижилтонд зарцуулсан, Байгал хамгаалах сангийн эргүүл, шалгалтын шатахуунд 1730.5 мянган төгрөг, Морин эргүүлийн урамшуулалт цалинд 100.0 мянган төгрөг тус тус зарцуулж нийт 3330.5 мянган төгрөг зарцуулж эцсийн үлдэгдэл 11191.6 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

ИТХТ-ийн тогтоолоор 2013 оны 1 сарын 24 ний 16 тоот тогтоолоор ойн зурвас байгуулах 6000.0 мянган төгрөг, Рашааны эх хамгаалах 2000.0 мянган төгрөг, БОХ-ын эргүүл хяналт-2500.0 мянган төгрөг, хогийн цэгийн хашаа 1500.0 мянган төгрөг тус тус зарцуулахаар баталсан байна.

Хяналтын түвшингийн хуулгатай ня-бо журналын боловсруулалтыг тулгахад зөрүүгүй байна.

СУМ ХӨГЖҮҮЛЭХ САН

Оны эхний үлдэгдэл 58179.8 мянган төгрөг, санхүүжилт 50000.0 мянган төгрөг, зээл төлөлтөөс 29950.0 мянган төгрөг, хүүгийн орлого 843.5 мянган төгрөг, нэр данс зөрүүтэй орлого 229.2 мянган төгрөг нийт орлого нь 81022.7 мянган төгрөг, зарлага нь зээлэнд 120300.0 мянган төгрөг, бараа материалд 167.1 мянган төгрөг, бусад зардалд 281.9 мянган төгрөг зарцуулж оны эцсийн үлдэгдэл 184523.5 мянган төгрөгийн үлдэгдэлтэй гарсан байна.

Журмаар зээлийн хүүгийн орлогын 50 хувиас хэтрүүлэлгүй үйл ажиллагааны зардалд зарцуулж болно гэсэн журмын дагуу зарцуулсан гэх боловч 4518.0 мянган төгрөгийн хүүгийн орлого оруулснаас 449.0 мянган төгрөгийг зарцуулсан байна. Зарлагыг тодруулбал:

- 80.0 мянган төгрөгөөр мэдээлэлийн самбар
- 86.1 мянган төгрөг баримт үдэгч
- 134.0 мянган төгрөгний принтерийн хор
- 30литр 48.0 мянган төгрөгний шатахуун

- 138.5 мянган төгрөгийн бичгийн хэрэгсэл авч батлагдсан төсвөөс 18.0 мянган төгрөгөөр хэтрүүлж, зарцуулалтын тайлангаар 10,5 мянган төгрөг дутуу зарцуулсаныг тооцоо хийж тушаагаагүй байна.

2013 оны эхний зээлийн авлага 73393.2 мянган төгрөг байснаас тайланд онд төлөлөгдсөн зээл 28671.0 мянган төгрөг төлж 44722.2 мянган төгрөгийн зээлийн төлөлөгдөөгүй үлдэгдэлтэй байна.

Урьд оны үлдэгдэл 34 хүнтэй холбоотой 2013.12.31-ны 73393.2 мянган төгрөгийн зээлийн үлдэгдлээс 2013 онд төлөгдсөн 28671.0 мянган төгрөг төлөгдөж 18 хүнтэй холбоотой 44722.2 мянган төгрөгийн зээлийн үлдэгдэлтэй байна. Үүнээс:

- Ганчанар ХХК 2009.11.10-нд 1 жилийн хугацаатай 3000.0 сая төгрөгийн зээл авч 360.0 мянган төгрөгийн хүү төлж 2011, 2012, 2013 оны хүүгийн төлбөр алдангигүйгээр 1080.0 мянган төгрөгийн хүүг тооцоогүй
- иргэн Б.Ганболд 1500.0 мянган төгрөг авч 180.0 мянган төгрөгийн эхний жилийн хүү төлж 3 жилийн хүү 540.0 мянган төгрөгийн хүү тооцоогүй,
- Ц.Бадраабал 3 жилийн хүү 360.0 мянган төгрөгийн хүү тооцоогүй, Д.Энхбат 4 жилийн хүү 224.0 мянган төгрөгийн хүү тооцоогүй,
- 2012 онд олгосон зээлээс Г.Ганбаатар 1000.0 мянган төгрөгийн зээл, 30.0 мянган төгрөгийн хүү төлөөгүй, Пунцаг-осор 2000.0 мянган төгрөг, 60.0 мянган төгрөгийн хүү төлөөгүй,
- Э.Элбэрэлт 3000.0 мянган төгрөг зээл, 18.0 мянган төгрөгийн хүү төлөгдөөгүй,
- Б.Адьяа 3000.0 мянган төгрөгийн зээл, 13.5 мянган төгрөгийн хүү төлөгдөөгүй,
- Ш.Галбаатар 5000.0 мянган төгрөгийн зээл, 150.0 мянган төгрөгийн хүү төлөгдөөгүй, байна.

Мөн онд шинээр 120300.0 мянган төгрөгийн зээл олгож, шинээр олгосон зээлээс 2122.5 мянган төгрөгийн хүүгийн орлого орж оны эцэст зээлийн үлдэгдэл 32 хүнд 122695.5 мянган төгрөгийн авлага үүсгэн бүртгэсэн байна.

ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САН

Цээл сумын ИТХурлын 2013 оны 4-р сарын 19-ний өдрийн 04 тоот тогтоолоор Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөтөлбөр арга хэмжээг санхүүжүүлэхдээ иргэдийн санал асуулга, багуудын иргэдийн нийтийн хурлаас хэлэлцэж баталсан эрэмбийг нэгтгэн сумын засаг даргын захирамжаар дараах жагсаалтыг баталсан байна. Үүнд:

1. Инженерийн хийцтэй нэгдсэн халаалтын шугам сүлжээ тавих 38.0 сая төгрөг
2. Сумын төвийн 2 км замыг хуванцар шон суулгаж хязгаарлах, замыг тэмдэгжүүлэх 10.0 сая төгрөг
3. Сумын төвийн 600 метр газарт гэрэлтүүлэг суурьлуулах сумын 3 өндөрлөг газарт гэрлэн чимэглэл хийх 16.0 сая төгрөг
4. 2р багийн нийтийн эзэмшлийн 12 айлын орон сууц, түүний орчмыг тохижуулах 48.0 сая
5. Хогийн зөөврийн цэг байгуулах 2 ширхэг 4.0 сая төгрөг
6. Иргэний нээлттэй танхимийг тохижуулах 5.0 сая төгрөг
7. Нийтийн эзэмшлийн ариун цэвэр, гудамж тайлбайн цэвэрлэгээ, хог зайлуулах, түрэх булах үйл ажиллагааны зардал, хогийн цэгийн хашааг цэгцлэх 14.0 сая төгрөг

8. 1дүгээр багийн нутаг дэвсгэрт жишиг гудамж бий болгох 4.0 сая
9. Сумын баяр наадмыг тэмдэглэн өнгөрүүлэх зардал 5.0 сая төгрөг
10. 2013 оны зураг төсөв хийлгэх зардал 14.0 сая төгрөг,
11. Хуурай хог хаягдлыг цэвэрлэх тээвэрлэх шатахууны зардал 5.0 сая төгрөг
12. Гэрэлтүүлэгийн цахилгааны зардал 1.6 сая төгрөг нийт 164.6 сая төгрөгийг зарцуулахаар баталсан байна.

Тайлант онд 121908.1 мянган төгрөг санхүүгийн дэмжлэг ирсэн, хадлангийн талбай ашигласны хурамжаар 6551.7 мянган төгрөг, мод зүсвэрийн орлого 3330.0 мянган төгрөг, андуурсан зээлийн хүү 195.7 мянган төгрөг нийт 131985.6 мянган төгрөгийн орлоготой байна.

ОНХСанд 76908.1 мянган төгрөгийн санхүүжилт, хадлангийн 6094.4 мянган төгрөг, мод зүсвэрийн орлого 2790.0 мянган төгрөг андуурагдсан гүйлгээ 150.7 мянган төгрөг, хаалганы үнэ 450.0 мянган төгрөг нийт 86393.2 мянган төгрөгийн орлого төвлөрч, хөрөнгө оруулалтаар хог түр хадгалах сав 4000.0 мянган төгрөг, хөрөө рам 10000.0 мянган төгрөг, Жишиг хашаа 4000.0 мянган төгрөг, үйл ажиллагааны зардал наадмын зардал 5000.0 мянган төгрөг, барилгын зургийн үнэ 11296.3 мянган төгрөг, хогийн бага оврын исүзү авто машин худалдан авахад 4150.0 мянган төгрөг, гэрлэн чимэглэл суурьлуулах 15990.0 мянган төгрөг, 12 айлын шугам засвар 47026.3 мянган төгрөг, Гэрэлтүүлгийн цахилгааны зардалд 860.1 мянган төгрөг нийт 106416.7 мянган төгрөг зарцуулсан байна.

Мөн хадлангийн төлбөрийн орлогоос хадлангийн талбай ашигласны гэрээний хяналтын шатахуунд 46.5 мянган төгрөг, мод зүсвэрийн орлогоос 2486.7 мянган төгрөг, аймгийн наадамд 7076.0 мянган төгрөг, андуурсан орлогоос 130.7 мянган төгрөгийг сум хөгжүүлэх санруу буцаасан нийт 9739.9 мянган төгрөгийг зарцуулж 15828.9 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

ОНХСангийн хөрөнгөөр хийгдсэн хөрөнгө оруулалтын ажлын 6-н ажилд шууд гэрээ, 2 ажилд нээлттэй тендер шалгаруулсан байна. 12 айлын сантехникийн засварын ажил 47026.3 мянган төгрөг, 16.0 сая төгрөгийн гэрэлтүүлэгийн ажилд олон нийтийн оролцооны аргаар тендерээр худалдан авах ажиллагааг зохион байгуулсан байна.

Тендер зохион байгуулах үйл ажиллагааг сумын ЗДТГын газар захирагчаар оролцох байтал сумын засаг дарга захиалагчийг төлөөлөн засаг даргын захирамжаар үнэлгээний хороог байгуулан ажиллуулсан байна.

Тендерийн хороо 2013.09.23-нд 7 хүний бүрэлдэхүүнтэй байгуулагдсаны дагуу 2013.11.07-нд тендерийн бичиг баримтыг боловсруулан Дөрвөн-лхагва ХХК, Ар булаг ХХК, Буянт гол ХХК-д хүргүүлсэн байна. Сантехник засварын өртгийг улсын төсөвчин Б.Болормаагаар хийлгэсэн 48104.5 мянган төгрөгийн төсөвт өртөг батлагдсан байна. Тендерийг харьцуулалтын аргаар шалгаруулж хамгийн бага үнийн санал ирүүлсэн Ар булаг ХХК нь 47026.3 мянган төгрөг тендерийг гүйцэтгэхээр шалгарч засварын ажлыг хийж гүйцэтгэсэн байна.

Мөн гудамжны гэрэлтүүлгийн тендерт орон нутгаас Өлзийсайхан ахлагчтай бүлэг, Ганбат ахлагчтай цахилгаан засварын олон нийтийн бүлэг, Улаанбаатар хотын ТОП гэрэл ХХК оролцож бага үнийн харьцуулалтын аргаар 15990.0 мянган төгрөгөөр Топ гэрэл ХХК нь шалгаран хугацаандаа бүрэн гүйцэтгэсэн байна.

Бидний дахин шалгалтын үр дүнд дээр дурдсан 9 хэсгүүдийн дотоод хяналтын ситем нь тухайн жилд хангалттай байсан ба нягтлан бодох бүртгэл нь Санхүүгийн тайлангийн зохистой үндэс болсон нь ажиглагдсан юм. Сайжруулах шаардлагатай

байж болох хэд хэдэн санхүүгийн хяналтын талаар удирдлагын захидалд тусгасан болно.

Аудитын явцад хийгдсэн гол шийдлүүд

5. Дараах хэсэгт Санхүүгийн тайлангийн аудит явцад гарсан гол асуудлуудыг хураангуйлан тэмдэглэсэн.

- Байгууллагын зардлын гүйцэтгэлийг бодитой бус тайлагнах нь төсвийн төлөвлөгөөг хийх, хянах, батлах, шинжилгээ судалгааны дүнд нөлөөлөх тул зардлыг үнэн зөв тайлагнаж байх.

6. Эдгээр асуудлуудыг ААГ болон Цээл сумын удирдлага авч үзэж хангалттайгаар шийдсэн. Бидний илрүүлсэн зүйлс болон дээрх санхүүгийн дотоод хяналтын талаар санал нь удирдлагын захидалд тусгагдсан байна. Санхүүгийн гүйлгээнүүд нь ххүлээн зөвшөөрөхүйц зохицуулагдсаныг тэмдэглэсэн.

Залруулагдаагүй алдаа

7. Аудитын стандарт нь ААГ-г аудитын явцад илэрсэн тодорхой биш болон залруулагдаагүй алдаанд анхаарал тавихыг шаарддаг. Аудитаар илэрсэн алдааг акт бичиж залруулсан болно.

Тайлбар мэдүүлгийн захидал

8. Аудитын үйл явцад ААГ хөндлөнгийн аудиторын хувьд удирдлагын зүгээс гаргасан баталгаанд тулгуурлах ёстой байсан ч хараат бус байдлын хувьд энэ батламжийг дагах нь зохистой байсангүй. Аудитын гүйцэтгэл бүрд /тайлбар мэдүүлгийн захидлаар/ санхүү бүртгэлийн ажилтанаас эдгээр баталгааг бичгээр баталгаажуулан олж авахыг хүсч байна.

Аудитын санал дүгнэлт

9. Аймгийн Аудитын газраас тус тайланд зөрчилгүй дүгнэлт гаргахаар санал оруулж байна.

Үндэсний Аудитын газрын харьяа Төв Аймгийн Аудитын газар

2014.03.10